



НИЙСЛЭЛИЙН ӨРГӨӨ АМАРЖИХ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 04 сарын 10 өдөр

Дугаар 4/30

Улаанбаатар хот

Ажилтнуудын ажлын гүйцэтгэлийг үнэлэх журмыг шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн "Журам батлах тухай" 5 дугаар тогтоолын гуравдугаар хавсралт, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн "Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай" 395 дугаар тогтоол, Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.4, ISO 9001:2015 Чанарын менежментийн тогтолцооны 7.1 шаардлага, Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын 2017 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн "Дүрэм батлах тухай" А/15 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан "Нийслэлийн Өргөө амаржих газрын дүрэм"-ийн 2.6.3 заалтууд, Эрүүл мэндийн яамны 2020 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн 4-1/1504 дугаартай албан бичиг, Удирдлагын багийн 2020 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Амаржих газрын "Ажилтнуудын ажлын гүйцэтгэлийг үнэлэх журам"-ыг нэгдүгээр, Удирдлагын багийн гишүүд, тасгийн эрхлэгч нарын ажлын үр дүн, гүйцэтгэлийн үнэлгээний шалгуур үзүүлэлтийг хоёрдугаар, Эмч нарын ажлын үр дүн, гүйцэтгэлийн үнэлгээний шалгуур үзүүлэлтийг гуравдугаар, Эх баригч, сувилагч эмнэлгийн тусгай мэргэжилтний ажлын үр дүн, гүйцэтгэлийн үнэлгээний шалгуур үзүүлэлтийг дөрөвдүгээр, Эрүүл мэндийн бусад ажилтнуудын ажлын үр дүн, гүйцэтгэлийн үнэлгээний шалгуур үзүүлэлтийг тавдугаар, тайлангийн ерөнхий загварыг зургаадугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Журмыг эрүүл мэндийн ажилтнуудад танилцуулж, Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулан, эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн ажилтнуудыг идэвхжүүлэх, урамшуулах зорилгоор хариуцсан алба, тасаг ажилтнуудын ажлын үр, дүн гүйцэтгэлийг бодитой үнэлж, дүгнэхийг Эмчилгээ эрхэлсэн орлогч дарга /О.Баянжаргал/, Байгууллагын бодлого төлөвлөлт хариуцсан орлогч дарга /Д.Наранцацралт/, албадын дарга тасгийн эрхлэгч нарт тус тус үүрэг болгосугай.

3. Ажилтнуудад улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгоход шаардагдах хөрөнгийг урамшууллын зардлаас гаргахыг Санхүү бүртгэлийн албаны дарга, ахлах нягтлан бодогч Ч.Гангэрэлд зөвшөөрсүгэй.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавин ажиллахыг Дотоод хяналт шалгалт эрхэлсэн ажилтан /Ц.Мөнхцэцэг/-т даалгасугай.

5. Тушаал гарсантай холбогдуулан Даргын 2019 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн А/27 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГАС  А.ДҮҮРЭНБИЛЭГ



Эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн ажилтнуудад ажлын үр дүн,
гүйцэтгэлээр мөнгөн урамшуулал олгох журам

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Энэхүү журмаар тус амаржих газрын эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн ажилтнуудын улирлын ажлын үр дүн, гүйцэтгэлийн үнэлгээг үндэслэн мөнгөн урамшуулал олгохтой холбогдсон харилцааг зохицуулна.
- 1.2 Ажилтнуудад улирлын ажлын үр дүн, гүйцэтгэлийн үнэлгээг үндэслэн мөнгөн урамшуулал олгоход шаардагдах хөрөнгийг жил бүрийн төсөвт тусгана.
- 1.3 Ажилтанд мөнгөн урамшуулал олгохдоо Хөдөлмөрийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хууль, эрх зүйн баримт бичгүүд, энэхүү журмыг мөрдлөг болгоно.
- 1.4 Ажилтанд мөнгөн урамшуулал олгох, ажлын үр дүн, гүйцэтгэлийг үнэлэхтэй холбоотой мэдээлэл нь нийт ажилтанд нээлттэй, ил тод байна.
- 1.5 Энэхүү журмын дагуу үнэлэгдсэн үнэлгээ нь ажилтанд мөнгөн урамшуулал олгох үндэслэл болно.
- 1.6 Мөнгөн урамшууллыг олгохдоо Нийслэлийн Өргөө амаржих газрын хөдөлмөрийн дотоод журам, албан тушаалын тодорхойлолт, хөдөлмөрийн гэрээнд заасан ажил үүргээ хангалттай гүйцэтгэсэн, ажлын байранд хөдөлмөрийн сахилга, ёс зүйн зөрчил гаргаагүй ажилтанд олгоно.

Хоёр. Ажлын үр дүн, гүйцэтгэлээр олгох мөнгөн урамшууллын хэмжээ

- 2.1. Улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг эрүүл мэндийн ажилтны ажлын үр дүн, гүйцэтгэлийг үндэслэн үндсэн цалингийн 7-20 хувиар сар бүр тооцож, улирал тутам олгоно.

Гурав. Ажлын үр дүн, гүйцэтгэлээр ажил дүгнэх аргачлал

- 3.1. Ажилтнуудын ажлын үр дүн, гүйцэтгэлийг ажил, мэргэжлийн онцлогийг харгалзан, тогтоосон шалгуур үзүүлэлтийн дагуу дүгнэнэ.
- 3.2. Удирдлагын зүгээс ажилтны ажлын гүйцэтгэлийн үнэлгээг дүгнэхэд Эмчилгээ эрхэлсэн орлогч дарга, Байгууллагын бодлого, төлөвлөлт хариуцсан орлогч дарга, Санхүү, бүртгэлийн алба, Хүний нөөцийн алба, Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ чанар, аюулгүй байдлын алба, Халдварын сэргийлэлт хяналтын алба, Сувилахуйн алба, Эрдэм шинжилгээ сургалт гадаад харилцааны алба, Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэсгийн хороо, Эмийн сан, Хангамж үйлчилгээний алба, Мэдээлэл олон нийттэй харилцах алба, Дотоод хяналт шалгалт эрхэлсэн ажилтан нар ажилтнуудын ажил дүгнэлтэд бичгээр саналаа холбогдох албан тушаалтанд өгнө.
- 3.3. Эмч, эрүүл мэндийн ажилтнууд улирлын ажлын тайланг тухайн улирлын сүүлийн сарын 23-ны өдрийн дотор холбогдох албан тушаалтанд өгнө.
- 3.4. Албадын дарга, тасгийн эрхлэгч нар хариуцсан алба, тасгийн ажилтнуудын ажлын үр дүн, гүйцэтгэлийн үнэлгээг хийж, улирлаар нь нэгтгэн дараагийн улирлын эхний сарын 02-ны дотор ирүүлнэ.

3.5. Ажилтнуудын ажил дүгнэх албан тушаалтан:

№	Дүгнэх албан тушаалтан	Дүгнүүлэх албан тушаалтан
3.1	Дарга	Эмчилгээ эрхэлсэн орлогч дарга, байгууллагын бодлого төлөвлөлт хариуцсан орлогч дарга, дотоод хяналт шалгалт эрхэлсэн ажилтан, хөдөлмөрийн эрүүл ахуй аюулгүй байдал хариуцсан ажилтан, албадын дарга нарын ажлын үр дүн, гүйцэтгэлийг үнэлнэ.
3.2	Эмчилгээ эрхэлсэн орлогч дарга	Тасгийн эрхлэгч, эмийн сангийн эрхлэгч, хоол зүйчийн ажлын үр дүн, гүйцэтгэлийг үнэлнэ.
3.3	Бодлого төлөвлөлт хариуцсан орлогч дарга	Статистикч эмч, даатгалын эмч, инженер, цахим мэдээлэл, олон нийттэй харилцах ажилтан, техникч, жолоочийн ажлын үр дүн, гүйцэтгэлийг үнэлнэ.
3.4	Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарын албаны дарга	Эмч, эм зүйч, тархвар судлаач нарын ажлын үр дүн, гүйцэтгэлийг үнэлнэ.
3.5	Сургалт, эрдэм шинжилгээ гадаад харилцааны албаны дарга	Сургалт эрдэм шинжилгээ гадаад харилцааны менежер, эрүүл мэндийн нийгмийн ажилтан, програм хангамж сүлжээний инженер, техник хангамжийн инженер, номын санчийн ажлын үр дүн, гүйцэтгэлийг үнэлнэ.
3.6	Хүний нөөцийн албаны дарга	Хүний нөөцийн менежер, бичиг хэрэг, архивч, сэтгэл зүйчийн ажлын үр дүн, гүйцэтгэлийг үнэлнэ.
3.7	Санхүү бүртгэлийн албаны дарга, ахлах нягтлан бодогч	Эрүүл мэндийн эдийн засагч, нягтлан бодогч, няравын ажлын үр дүн, гүйцэтгэлийг үнэлнэ.
3.8	Сувилахуйн албаны дарга	Тасгийн арга зүйч эх баригч, арга зүйч лаборант, арга зүйч сувилагч, эх баригч, сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтний ажлын үр дүн, гүйцэтгэлийн үнэлгээг үнэлнэ.
3.9	Хангамж үйлчилгээний албаны дарга	Сантехникийн слесарь, мужаан, тасгийн няравын (тасгуудаас санал авах) ажлын үр дүн, гүйцэтгэлийг үнэлнэ.
3.10	Засвар, үйлчилгээ цэвэрлэгээний хэсгийн ахлагч	Цахилгаанчин, лифтчин, хүчилтөрөгчийн операторич, асрагч нарын ажлын үр дүн, гүйцэтгэлийг үнэлнэ.
3.11	Тасгийн эрхлэгч нар	Тухайн тасгийн эмч нарын ажлын үр дүн гүйцэтгэлийг үнэлж, Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ чанар аюулгүй байдлын албанд ирүүлнэ.
3.12	Мэс засал, мэдээгүйжүүлэг, эрчимт эмчилгээний хэсгийн ахлагч	Мэдээгүйжүүлэг эрчимт эмчилгээний эмч нарын ажлын үр дүн гүйцэтгэлийг үнэлж, Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ чанар аюулгүй байдлын албанд ирүүлнэ.
3.13	Тасгийн арга зүйч эх баригч, сувилагч нар	Сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтний ажлын үр дүн гүйцэтгэлийг үнэлж Сувилахуйн албанд ирүүлнэ.

Дөрөв. Ажлын үр дүн, гүйцэтгэлээр нэмэгдэл хөлс олгоход тавигдах шаардлага, баримтлах зарчим

- 4.1. Ажил дүгнэж байгаа орлогч дарга, албадын дарга, тасгийн эрхлэгч, тасгийн арга зүйч эх баригч, сувилагч нар дараах үзүүлэлтээр ажлын гүйцэтгэл, үр дүнг 100 хүртэл оноогоор дүгнэнэ.

№	Үзүүлэлт	Оноо
А.Эрүүл мэндийн ажилтанд тавигдах нийтлэг шалгуур үзүүлэлт		
1	Үйлчилгээний чанар аюулгүй байдал Харилцаа хандлага, ёс суртахууны хэм хэмжээ	30 оноо
2	Ажлын ачаалал, хариуцлага, цаг ашиглалт, өмч хамгаалал, анхан шатны бичиг баримтын хөтлөлт	20 оноо
3	Эмнэлгийн тусламж үйлчилгээнд оруулсан хувь нэмэр, олон нийтийн арга хэмжээнд оролцсон байдал	20 оноо
		Нийт 70 оноо
Б.Тусгай шалгуур үзүүлэлт		
Эмнэлгийн мэргэжилтэн		
4	Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдал	30 оноо
Эрүүл мэндийн бусад ажилтан		
5	Хариуцсан ажлын чанар	30 оноо
		Бүгд 100 оноо

- 4.2.Эрүүл мэндийн ажилтны ажлын үр дүн, гүйцэтгэлийг дараах үнэлгээгээр сар бүрээр дүгнэж, үнэлгээ өгсөн үндэслэлээ бичнэ.

Бүх шалгуурын биелэлтийн хувь	Ажлын үр дүнгийн үнэлгээ
90-100	"А" Бүрэн хангалттай
80-89	"В" Хангалттай
71-79	"С" Дунд хангалттай
71 доош	Хангалтгүй

- 4.3.Мөнгөн урамшууллын хэмжээг тооцох хувь

№	Бүх шалгуурын биелэлтийн хувь	Интерваль	Үнэлгээ	Албан тушаалын үндсэн цалингаас урамшуулал тооцох хувь (сард)
4.3.1	71-75	5	С	7
4.3.2	76-79	4	С	8
4.3.3	80-84	5	В	9
4.3.4	85-89	5	В	10
4.3.5	90	1	А	11
4.3.6	91	1	А	12
4.3.7	92	1	А	13
4.3.8	93	1	А	14
4.3.9	94	1	А	15
4.3.10	95	1	А	16
4.3.11	96	1	А	17
4.3.12	97	1	А	18
4.3.13	98	1	А	19
4.3.14	99-100	2	А	20

- 4.4.Ажилтны ажлын үр дүн, гүйцэтгэлийн үнэлгээний дагуу мөнгөн урамшууллыг сар бүрээр тооцож, улиралд нэг удаа олгоно.

- 4.5.Ажилтанд дараах тохиолдлуудад ажлын үр дүн гүйцэтгэлээр олгох нэмэгдэл хөлс урамшууллыг тухайн улиралд олгохгүй.

№	Шалгуур үзүүлэлт	Тайлбар
4.5.1	Ажлын үзүүлэлт	Үр дүнгийн шалгуурын биелэлт 71 –ээс доош хувьтай үнэлэгдсэн
4.5.2	Сахилгын шийтгэл	Даргын тушаалаар сахилгын шийтгэл ногдуулснаас хойш хуанлийн нэг жил буюу шийтгэл ногдуулсан шийдвэрийг гаргасан он, сар, өдрөөс хойш бүтэн 12 сар өнгөрөх хүртэл хугацаанд
4.5.3	Ажлын тайланг өгөөгүй болон хугацаа хоцроосон	Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр /хүнд гэмтэх, хүнд өвдөх, ар гэрийн гачигдал гарах/ тайлан хоцроох, ажлын тайлан өгөөгүй
4.5.4	Туршилтын хугацаанд	Хөдөлмөрийн гэрээний туршилтын 3 сарын хугацаанд
4.5.5	Ажлын цаг ашиглалт	Гадаад, дотоодын урт богино хугацааны сургалтанд хамрагдсан, цалинтай, цалингүй чөлөө авсан, хөдөлмөрийн чадвар түр алдалт, ээлжийн амралтын хугацааг тооцож, ажилласан хоногт ногдох урамшуулал олгоно.
4.5.6	Байгууллагын нэр хүндэд сөргөөр нөлөөлсөн мэдээлэл	Олон нийтийн цахим сүлжээ, үйлчлүүлэгч ар гэрийнхэнд сөрөг мэдээ, мэдээлэл мэдээлэх, нийтлэх, тараах
4.5.7	Эд хөрөнгийн ашиглалт, хамгаалалт	Байгууллагын эд хөрөнгө, тоног төхөөрөмж, эм тариа, эмнэлгийн хэрэгслийг зүй бусаар ашиглах, шамшигдуулах, байгууллагаас гаргах, гаргахыг оролдох
4.5.8	Үйлчилгээний чанар, стандарт хэрэгжилт	Үйлчилгээний чанар, стандарт хангаагүйгээс үйлчлүүлэгч хохирсон, гомдол санал гарсан
4.5.9	Өргөдөл, гомдлын шийдвэрлэлт	Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийг цаг тухайд нь шийдвэрлээгүйгээс үйлчлүүлэгч, ар гэрийнхэн, байгууллагад асуудал үүссэн

4.6. Улирлын үр дүнгийн урамшууллыг бүтэн олгох шалгуур үзүүлэлт

№	Шалгуур үзүүлэлт	Тайлбар
4.6.1	Эмнэлгийн тусламж үйлчилгээнд оруулсан хувь нэмэр	5-10 сая төгрөг 1 улирал 10-50 сая төгрөг 2 улирал 50-100 сая төгрөг 3 улирал 100 дээш сая төгрөг 4 улирал
4.6.2	Олон улсын шинжлэх ухааны сэтгүүлд судалгаа, шинжилгээ, өгүүлэл хэвлүүлсэн, илтгэл хэлэлцүүлсэн	Өөрийн хийж буй судалгаатай холбоотой материал хэвлүүлэх /1,2-р судлаачаар/
4.6.3	Удирдамж, гарын авлага боловсруулах	Эмнэлгийн тусламж үйлчилгээнд мөрдөгдөх удирдамж, гарын авлага боловсруулж холбогдох эрх бүхий байгууллагаар баталгаажуулсан
4.6.4	Оюуны өмчийн гэрчилгээ болон ашигтай загварын гэрчилгээ авсан	Эмнэлгийн тусламж үйлчилгээг сайжруулах оюуны өмчтэй болсон /тухайн багт/

4.6.4	Оюуны өмчийн гэрчилгээ болон ашигтай загварын гэрчилгээ авсан	Эмнэлгийн тусламж үйлчилгээг сайжруулах оюуны өмчтэй болсон /тухайн багт/
4.6.5	Тэмцээн уралдаан	Гадаад орон, байгууллагуудын хоорондох тэмцээн уралдаанд оролцож тэргүүн байранд шалгарсан /үндсэн багийн гишүүдэд/
4.6.6	Томилолт	Харъяалах дээд байгууллагын шийдвэр, томилолтоор ижил төст байгууллагад үүрэгт ажлаа гүйцэтгэсэн

4.7.Ажилтнуудын ажил дүгнэсэн нэгдсэн үнэлгээг холбогдох албан тушаалтан Удирдлагын багийн хурлаар хэлэлцүүлнэ.

4.8.Ажилтнуудад мөнгөн урамшуулал олгох шийдвэрийг амаржих газрын Дарга гаргаж, хүний нөөцийн алба тушаалыг боловсруулан баталгаажуулж, дараагийн улирлын эхний сарын 08-ны дотор багтаан Санхүү, бүртгэлийн албанд өгнө.

4.9.Мөнгөн урамшууллыг тухайн улирлын дараа сарын 15-ны дотор олгоно.

4.10.Жилийн эцсийн үнэлгээг 12 дугаар сард багтаан олгоно.

Нийслэлийн Өргөө амаржих газрын даргын
2020 оны 04 дүгээр сарын 10-ний өдрийн
...4/30 тушаалын зургаадугаар хавсралт

1119287569 9077006

Тайлангийн ерөнхий загвар

Ажилтны нэр:.....

Албан тушаал:

Тасаг:.....

№	Шалгуур үзүүлэлт	Шалгуурын дагуу хийсэн ажил	Нийт	Үнэлгээ
А.Эрүүл мэндийн ажилтанд тавигдах нийтлэг шалгуур үзүүлэлт				
1	Үйлчилгээний чанар, аюулгүй байдал, харилцаа хандлага, ёс суртахууны хэм хэмжээ			
2	Ажлын ачаалал, цаг ашиглалт, хариуцлага Анхан шатны бичиг баримтын хөтлөлт			
3	Эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд оруулсан хувь нэмэр, олон нийтийн арга хэмжээнд оролцсон байдал			
				Нийт 70 оноо
Б.Тусгай шалгуур үзүүлэлт				
Эмнэлгийн мэргэжилтэн				
4	Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдал			
				Нийт 30 оноо
Эрүүл мэндийн бусад ажилтан				
5	Хариуцсан ажлын чанар			
				Нийт оноо 30

Нийслэлийн Өргөө амаржих газрын даргын
2020 оны 04 дүгээр сарын 10-ний өдрийн
А/30 тушаалын хоёрдугаар хавсралт

1119267569 9077006

Удирдлагын багийн гишүүд, тасгийн эрхлэгч
нарын ажлын гүйцэтгэлийн үнэлгээний шалгуур үзүүлэлт

№	Шалгуур үзүүлэлт	Шалгуурын дагуу хийсэн ажил	Авах оноо	Үнэлгээ
А.НИЙТЛЭГ ШАЛГУУР				
3. Үйлчилгээ хүлээгдэл, чирэгдэл Харилцаа хандлага, ёс суртахууны хэм хэмжээ				
1.1	Албан тушаалын хүрээнд алба, тасаг, ажилтнууд болон үйлчлүүлэгчдээс ирсэн санал, хүсэлтийн шийдвэрлэлт	Цаг хугацаанд нь хүлээгдэл чирэгдэлгүй шийдвэрлэсэн байдал, хэрэгжүүлсэн үйл ажиллагаа	5 оноо	1 удаа- 4 оноо 2-3 удаа – 3 оноо 4 ба түүнээс дээш – 0 оноо
1.2	Харилцаа, хандлага, ёс суртахууны хэм, хэмжээ	Удирдах ажилтан, эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн ажилтан, үйлчлүүлэгчтэй харилцах хэм хэмжээг мөрдөн ажиллаагүй / Ёс зүйн доголдол гаргасан эсэх/	20 оноо	Ёс зүйн хэсгийн хороонд хандсан, хурлаар орсон бол 20 оноо Асуудал үүсгэсэн бол 15 оноо
1.3	Бусад албан тушаалтан, алба, тасагтай хамтран зохион байгуулсан ажил	Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулах зорилгоор өдөрлөг, аян, хурал, сургалт зохион байгуулж үр дүнг тооцсон байдал	5 оноо	Тийм, үгүй
				Нийт 30 оноо
4. Ажлын ачаалал, цаг ашиглалт, хариуцлага Анхан шатны бичиг баримтын хөтлөлт				
2.1	Ажлын цаг ашиглалт	Эмч нарын яриа, тасгийн яриа, тойрон үзлэг, байгууллагын хөгжлийн төлөө яриа, сургалтын бүртгэл /эмнэлгийн магадлагаа, ээлжийн амралтын хугацаа тооцогдохгүй/	5 оноо	1 удаа- 2 оноо 2-3 удаа – 3 оноо 4 ба түүнээс дээш – 0 оноо
2.2	Анхан шатны бичиг баримтын хөтлөлт	Хариутай болон хариугүй албан бичгийн биелэлт, хэрэгжилт, шийдвэрлэлтийг хугацаанд нь гаргах албан бичгийн дагуу зохион байгуулсан ажил, үр дүн https://erp.ulaanbaatar.mn/ , https://edoc.ulaanbaatar.mn/ програм ашиглалт, Анхан шатны баримт, бичгийн хөтлөлт, үйлчлүүлэгчид мэдээлэл дутуу өгсөнөөс ойлгомжгүй байдал үүссэн	5 оноо	1 удаа- 2 оноо 2-3 удаа – 3 оноо 4 ба түүнээс дээш – 0 оноо

2.3.	Өмч хөрөнгийн ашиглалт	Тасаг, албаны өмч, хөрөнгийн ашиглалт, хамгаалалт, аюулгүй ажиллагаанд хяналт тавьж ажиллах	5 оноо	1 удаа- 2 оноо 2 ба түүнээс дээш – 0 оноо
2.4.	Төлөвлөгөө, тайлан, Удирдах дээд байгууллага, байгууллагын даргын өгсөн үүрэг даалгаврын биелэлт	Байгууллага, алба, тасгийн үйл ажиллагааны төлөвлөгөөг хагас, бүтэн жилээр гаргаж, төлөвлөгөөний биелэлтийг тасгийн эрхлэгч, албадын дарга нараас авч нэгтгэх Үйл ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээлэл, цаг үеийн ажил, мэргэжлийн санамж, зөвлөмжийг байгууллагын цахим хуудсаар болон олон нийтийн мэдээллийн хэрэгслэлүүдээр мэдээлэх	5 оноо	Хугацаа хоцроосон бол -3 оноо Өгөөгүй, биелүүлээгүй бол-0 оноо

Нийт 20 оноо

3.Эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд оруулсан хувь нэмэр

3.1.	Үргүй зардал, шинэ санаа	Үргүй зардлыг багасах, шинэ бүтээл, оновчтой санааг нэвтрүүлсэн	5 оноо	Тийм, үгүй
3.2.	Албан тушаалын хүрээнд байгууллагын үйл ажиллагааны үндсэн үзүүлэлтэнд хийсэн дүн шинжилгээ	Байгууллагын үйл ажиллагааны үндсэн үзүүлэлт дээр тулгуурлан дүн шинжилгээ хийж, сайжруулах арга хэмжээ авч Удирдлагын багаар хэлэлцүүлсэн	10 оноо	Тийм, үгүй
3.3.	Хамт олны дунд удирдан зохион байгуулсан ажил, үр дүн, оролцоо	Улирлын турш удирдлага, хамт олны дунд зохион байгуулсан ажил, олон нийтийн ажлын оролцоо	5 оноо	Тийм, үгүй

Нийт 20 оноо

Бүгд 70

Б.ТУСГАЙ ШАЛГУУР

4.Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар сайжруулах чиглэлд

4.1.	Албан тушаалын тодорхойлолтод заагдсан ажлын гүйцэтгэл	<u>Удирдлагын багийн гишүүд:</u> Эмнэлгийн тусламж үйлчилгээг сайжруулахаар боловсруулсан тушаал, журам, албан бичиг төлөвлөлт	5 оноо	1 удаа- 2 оноо 2-3 удаа – 3 оноо 4 ба түүнээс дээш –5 оноо
		<u>Тасгийн эрхлэгч нар</u> ЭҮД, ноцтой хүндрэл, үндсэн оношийн зөрүү гаргасан байдал /Эх нярайн ноцтой хүндрэл, эндэгдэл, амьгүй төрөлт гарсан бол, хариуцсан тасаг, нэгжийн эмчилгээ, оношилгоо, сувилахуйн тусламж үйлчилгээний талаар судалгаатай байж, улирал бүр эмчилгээ үйлчилгээний үр дүнг тооцох, дотоод хяналт үнэлгээг тогтмолжуулах, мэргэжлийн алдаа, зөрчил гаргах, хариуцсан эд хөрөнгийн ашиглалт,	5 оноо	1 удаа- 2 оноо 2-3 удаа – 3 оноо 4 ба түүнээс дээш –0 оноо

		хамгаалалт, бусад алба, тасаг нэгжтэй хамтран ажилласан байдал /		
4.2.	Халдвараас сэргийлэх хяналт, халдвар хамгааллын дэглэмийг мөрдүүлэх чиглэлд хийсэн ажил, үр дүн	ХСХА-аас авсан мэдээлэл, стандартын дагуу хувцаслалт, Халдвар хамгаалалын дэглэм мөрдөлт/ Эмнэлгээс шалтгаалах халдварыг цаг тухайд нь мэдээлж, хариу арга хэмжээг авсан байдал (холбогдох тайлан мэдээг цаг хугацаанд нь өгсөн байх), Халдвар хамгааллын дэглэмтэй холбоотой тушаал шийдвэр, удирдамжийн хэрэгжилт /сар бүр сорил, гардан үйлдэл, ажиглалт, чек листээр гэх мэт ээлжлэн үнэлсэн байх/	7 оноо	1 удаа- 2 оноо 2-3 удаа – 3 оноо 4 ба түүнээс дээш –0 оноо
4.3.	Гомдол	ЗГ-ын 11-11, Хэрэглэгчийн үйлчилгээний төвийн 1800-1200, удирдах дээд байгууллагаас ирсэн аман, бичгэн гомдол	8 оноо	Гаргасан 0
4.4	Хяналт, үнэлгээ, шинжилгээ хийсэн байдал, түүний үр дүн	<u>Удирдлагын багийн гишүүд</u> Дэмжлэгт хяналт үнэлгээг тогтмолжуулж, үр дүнг тооцон, зөрчил дутагдлыг арилгах арга хэмжээ авсан байх <u>Тасгийн эрхлэгч нар</u> Тухайн улиралд тасаг, албандаа хийсэн ижил мэргэжилтний үнэлгээний хувь, үр дүн, цаашид дэвшүүлсэн асуудлыг баримттай бичнэ/, сайжруулах арга хэмжээ авсан байдал	5 оноо	Хийгээгүй – 0 оноо Баримтгүй бол-3 оноо
4.5	Стандарт мөрдөлт, хөдөлмөрийн дотоод журам мөрдөлт	Үйл ажиллагаатай холбоотой тушаал шийдвэр, удирдамжийн хэрэгжилт, авсан арга хэмжээ, үр дүн тооцсон байх Тусгайлан байгуулсан комисс, баг, зөвлөл, ажлын хэсэгт ажилласан байдал / ирц, хурлын тэмдэглэл баталгаажуулалт/	5 оноо	Хийгээгүй – 0 оноо Баримтгүй бол-3 оноо
Нийт оноо 30				

Нийслэлийн Өргөө амаржих газрын даргын
2020 оны 04 дүгээр сарын 10-ний өдрийн
А/30 тушаалын гуравдугаар хавсралт

1110267563 д. 9077006

Эмч нарын ажлын гүйцэтгэлийн үнэлгээний шалгуур үзүүлэлт

№	Шалгуур үзүүлэлт	Шалгуурын дагуу хийсэн ажил	Авах оноо	Үнэлгээ
А.НИЙТЛЭГ ШАЛГУУР				
2. Үйлчилгээ хүлээгдэл, чирэгдэл Харилцаа хандлага, ёс суртахууны хэм хэмжээ				
1.1	Хүлээгдэл, чирэгдэл үүсгэсэн байдал	Байгууллагаас гарах бичиг баримтын хөтлөлт /СТ-4, амбулаторийн карт бичилт, нярайн ягаан дэвтэр, солилцох хуудас, эд, эсийн шинжилгээний хариу, үйлчлүүлэгчид мэдээлэл дутуу өгсөнөөс ойлгомжгүй байдал үүсгэсэн, АШББ /	5 оноо	1 удаа- 1 оноо 2-3 удаа – 3 оноо 4 ба түүнээс дээш – 5 оноо
1.2	Харилцаа, хандлага, ёс суртахууны хэм, хэмжээ	Удирдах ажилтан, эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн ажилтан, үйлчлүүлэгчтэй харилцах хэм хэмжээг мөрдөн ажиллаагүй / Ёс зүйн доголдол гаргасан эсэх/	20 оноо	Ёс зүйн хэсгийн хороонд хандсан, хурлаар орсон бол 20 оноо Асуудал үүсгэсэн бол 15 оноо
1.3	Үйлчилгээний сэтгэл ханамж /Хамт олон, үйлчлүүлэгч/	Санал хүсэлтийн хайрцаг, дэвтэр, талархалын модонд ирсэн/ тасагт ирсэн сөрөг сэтгэл ханамж- МОНХА-аас авсан нэгдсэн дүгнэлт орно.	5 оноо	Сэтгэл ханамжгүй байдал 1 тохиолдол- 1 оноо 2-3 тохолдол – 3 оноо 4 ба түүнээс дээш – 5 оноо
				Нийт 30 оноо
2.Ажлын ачаалал, цаг ашиглалт, хариуцлага Анхан шатны бичиг баримтын хөтлөлт				
2.1.	Ажлын цаг ашиглалт, өмч хамгаалал	Эмч нарын яриа, тасгийн яриа, тойрон үзлэг, тасгийн яриа, тойрон үзлэг, сургалтуудын бүртгэл /албан ёсны лист, ээлжийн амралт тооцогдохгүй/ Акт, чөлөөтэй, сургалттай байсан ажлын цагийг тасгийн эрхлэгч, удирдлага тогтоож тооцно	5 оноо	1 удаа- 2 оноо 2-3 удаа – 3 оноо 4 ба түүнээс дээш – 0 оноо
2.2	Чек лист хөтлөлт /ИМУ/	/Тухайн улиралд тасаг, албандаа хийсэн ижил мэргэжилтний үнэлгээний хувь, үр дүн, цаашид дэвшүүлсэн асуудлыг баримттай бичнэ/	5 оноо	Хийгээгүй бол-5 оноо Хийсэн баримтгүй бол -3 оноо Баримттай дүгнэлттэй бол-5 оноо өгнө
2.3.	Анхан шатны бичиг баримтын хөтлөлт	АШББ-ны хөтлөлт, төрөлтийн түүх, өвчний түүхийн хөтлөлт, бусад бүртгэлийн баримт	5 оноо	1-2 удаа – 2-оноо 3-4 удаа – 3 оноо 5 ба түүнээс олон 5 оноо

2.4.	Тайлан, үүрэг даалгаварын биелэлт	Тайлан өгсөн байдал, Үүрэг даалгаврын биелэлт	5 оноо	Өгөөгүй, биелүүлээгүй бол-5 оноо
Нийт 20 оноо				
3.Эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд оруулсан хувь нэмэр				
3.1.	Үргүй зардлыг бууруулсан (шинэ санаа)	Үйл ажиллагаанд хэрэглэгдсэн бол үр дүнгийн урамшуулал тухайн улиралд бүтэн олгох шалгуур үзүүлэлтээр дүгнэгдэнэ	5 оноо	Үр ашгийг нь тооцно
3.2.	Ноцтой хүндрэлд өөрөө тусламж үзүүлсэн байдал	Байгууллагын үндсэн үзүүлэлтэнд нөлөөлсөн бол үр дүнгийн урамшуулал тухайн улиралд бүтэн олгох шалгуур үзүүлэлтээр дүгнэгдэнэ	10 оноо	
3.3.	Олон нийтийн ажлын оролцоо	Улирлын турш удирдлага, хамт олноос зохион байгуулагдсан бүх ажлын оролцоо	5 оноо	1 удаа- 2 оноо 2 ба түүнээс дээш – 5 оноо
Нийт 20 оноо				
Бүгд 70				
Б.ТУСГАЙ ШАЛГУУР				
4.Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар сайжруулах чиглэлд				
4.1.	Албан тушаалын тодорхойлолтод заагдсан ажлын гүйцэтгэл	ЭҮД, ноцтой хүндрэл, үндсэн оношийн гаргасан байдал	5 оноо	Гаргасан-5 оноо
4.2.	Халдвар хамгааллын дэглэмийг мөрдөж байгаа байдал	ХСХА-аас авсан мэдээлэл, стандартын дагуу хувцаслалт, Халдвар хамгаалалын дэглэм мөрдөлт	7 оноо	Гаргасан-7 оноо
4.3.	Гомдол	ЗГ-ын 11-11, Хэрэглэгчийн үйлчилгээний төвийн 1800-1200, удирдах дээд байгууллагаас ирсэн гомдол, аман, бичгэн гомдол/	8 оноо	Гаргасан-8 оноо
4.4.	Эрүүл мэндийн боловсрол олголт, хичээл заасан байдал	Тасаг, албандаа мэдээллийн суваг, байгууллагын веб сайтаар үйлчлүүлэгчид мэдээлэл өгсөн байдал	5 оноо	Өгөөгүй – 5 оноо Өгсөн баримтгүй бол-3 оноо
4.5.	Эмчилгээний стандарт мөрдөлт, дотоод журмын зөрчил	ЭМТҮЧАБА-ны хурлаар орсон, Чанарын талон цоолуулсан тохиолдол	5 оноо	Орсон, Цоолуулсан, гаргасан бол -5 оноо
Нийт оноо 30				

Нийслэлийн Өргөө амаржих газрын даргын
2020 оны 04 дүгээр сарын 10-ний өдрийн
А/30 тушаалын дөрөвдүгээр хавсралт

1119287509 д. 9077006

Эх баригч, сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтний ажлын гүйцэтгэлийн
үнэлгээний шалгуур үзүүлэлт

№	Шалгуур үзүүлэлт	Шалгуурын дагуу хийсэн ажил	Авах оноо	Үнэлгээ
А.НИЙТЛЭГ ШАЛГУУР				
1. Үйлчилгээ хүлээгдэл, чирэгдэл				
Харилцаа хандлага, ёс суртахууны хэм хэмжээ				
1.1	Үзлэг, шинжилгээ, эмчилгээг чирэгдэлгүй, хүлээлгэхгүй, тасралтгүй үзүүлсэн байдал	Тусламж үйлчилгээг цаг хугацаанд нь хийсэн эсэх, хүртээмж, түргэн шуурхай байдал - Гардан тусламж үйлчилгээг үзүүлээгүй, орхигдуулсан эсэх, хайнга хандах - Эмчилгээ захиалаагүй, түүхэнд хорт эмийн зарцуулалт тэмдэглэсэн эсэх, эмийн үнийг буруу бодох - Шинжилгээ орхигдуулах хариуг түүхэнд үл наах - Эх, нярай, үйлчлүүлэгчдэд угтах, эргэх үйлчилгээ үзүүлсэн эсэх - Хүндрэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч үзүүлээгүй, цаг хугацаа хожимдсон эсэх	5 оноо	Тохиолдол бүрээс -1 оноо Тухайн тохиолдлын давтамж бүрийн тоогоор оноо хасагдана.
1.2	Харилцаа хандлага, ёс суртахууны хэм хэмжээ	- Ёс зүйн хурлаар орсон эсэх. - Ажлын дүрэмт хувцас өмсөлт, энгэрийн тэмдэг зүүлт - Эмнэлгийн мэргэжилтний хоорондын болон үйлчлүүлэгчтэй харилцах харилцаа зөрчсөн / ЭМС-ын № 406/	20 оноо	Ёс зүйн хэсгийн хорооны хурлаар орсон бол -20 оноо ЭМС-ын № 406 тоот зөрчвөл - 20 оноо Дүрэмт хувцаслалт зөрчвөл тохиолдлын тоогоор хасагдана.
1.3	Үйлчилгээний сэтгэл ханамж / Хамт олон, үйлчлүүлэгч/	Үйлчлүүлэгчдийн талархал / амаар, бичгээр, талархлын мод, санал хүсэлтийн хайрцаг, удирдах дээд байгууллагаас, хамт олны сэтгэл ханамжийн судалгаа	5 оноо	Сэтгэл ханамжгүй байдал 1 тохиолдол-1 оноо 2-3 тохиолдол-3 оноо 4 ба түүнээс дээш - 5 оноо
				Нийт 30 оноо
2. Ажлын ачаалал, цаг ашиглалт, хариуцлага, Анхан шатны бичиг баримтын хөтлөлт				

2.1.	Ажлын цаг ашиглалт, ачаалал	- Өвчтэй цаг / баталгаа/ - Хувийн чөлөө авсан цаг / баталгаа / - Ажлаас хоцорсон цаг, минут, ажлын байр орхиж явах. / хурууны цахим бүртгэл /, ээлж дураараа солих - Сургалтуудын бүртгэл - Ажлын ачаалал	5 оноо	1 удаа - 2 оноо 2-3 удаа - 3 оноо 4 ба түүнээс дээш – 0 оноо
2.2	Анхан шатны бичиг баримтын хөтлөлт	- ЭМС-ын № 611 тоот тушаал, журмын зөрчил - Жижүүрийн мэдээ мэдээлэх / мэдээ өгөөгүй тохиолдол/ - Баримт бичгийг дутуу болон буруу бөглөх / түүх, бусад маягт/ - Тусламж үзүүлсэн эсэхээ тэмдэглээгүй, нэр бүтэн бус - Он, сар өдөр, цаг хугацааг бичээгүй - Тайлан өгсөн байдал, үүрэг даалгаврын биелэлт	5 оноо	1 удаа – 2 оноо 2-3 удаа – 3 оноо 4 ба түүнээс дээш 0 оноо
2.3	Ижил мэргэжилтний үнэлгээ, дүгнэлт хийсэн эсэх	- Сэдэв, хувь, үр дүн сайжруулах асуудлыг тодорхой бичнэ.	5 оноо	Хийгээгүй бол -5 оноо Хийсэн баримтгүй бол -3 оноо Баримттай дүгнэлттэй бол +5 оноо өгнө
2.4.	Өмч хөрөнгийн ашиглалт	Эмнэлгийн тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн бүртгэл, хөтлөлт тэмдэглэгээ, хадгалалт, өөрөөс шалтгаалсан эвдрэл гэмтэл гаргасан эсэх	5 оноо	1 удаа- 1 оноо 2 ба түүнээс дээш 0 оноо
Нийт 20 оноо				
3. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд оруулсан хувь нэмэр				
3.1.	Үргүй зардал, шинэ санаа	Үргүй зардлыг багасах, шинэ бүтээл, оновчтой санааг сувилахуйн тусламж үйлчилгээнд нэвтрүүлсэн.	5 оноо	1 -2 бүтээл бол +10 оноо 3-аас дээш +15 оноо
3.2	Ноцтой хүндрэлийн үед тусламж үйлчилгээ үзүүлсэн байдал	Хүнд эх,нярай,эмчлүүлэгчийг хүндрэлээс урьдчилан сэргийлэх, тусламж үзүүлэх, эрсдлээс сэргийлэх, ноцтой хүндрэлийн үед үзүүлсэн тусламж үйлчилгээ	10 оноо	2-3 удаа бол -5 оноо 4-ээс дээш 0 оноо
3.3.	Олон нийтийн ажлын оролцоо	- Өдөрлөг, аянд оролцсон байдал - Удирдлага хамт олноос зохион байгуулсан ажлын оролцоо - Их цэвэрлэгээ	5 оноо	1 удаа -2 оноо 2 ба түүнээс дээш -5 оноо

Б.ТУСГАЙ ШАЛГУУР

4. Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдал стандарт мөрдөлт

4.1.	Албан тушаалын тодорхойлолтод заагдсан ажлын гүйцэтгэл	- Эх нярай, үйлчлүүлэгчийн хяналт, асаргаа сувилгааны чанар, багаар ажилласан байдал, албан тушаалын тодорхойлолтод заагдсан ажлын гүйцэтгэл	5 оноо	Тохиолдол бүрээс -1 оноо Тухайн тохиолдлын давтамж бүрийн тоогоор оноо хасагдана.
4.2.	Халдвар хамгааллын дэглэмийг мөрдөж байгаа байдал	- Гарын ариун цэвэр сахилтын түвшин %, гар угаалт - Ажилбарын үед халдвар хамгааллын дэглэм, ариун материалтай харьцаж байгаа байдал - Хувийн хамгаалах хувцас хэрэгсэл өмсөлт - Үйлчлүүлэгчийн өрөөний эмх цэгцэнд хяналт тавьсан байдал - Хог хаягдлын ангилан ялгалт, зөөвөрлөлт, тэмдэглэгээ, аюулгүй хайрцгийн хэрэглээ	7 оноо	1 удаа- 2 оноо 2-3 удаа - 3 оноо 4 ба түүнээс дээш 0 оноо
4.3.	Эмчилгээ, сувилгаа, үйлчилгээний талаар гаргасан гомдол	- ЗГ-ын 11-11, 1800-1200, хэвлэл мэдээлэл - Судалгаагаар, бичгээр, утсаар, амаар, нэрээр, удирдах дээд байгууллагаас ирсэн гомдол	8 оноо	Гаргасан -8 оноо
4.4	Эрүүл мэндийн боловсрол олголт, зөвлөгөө өгч хичээл заасан байдал	- Сэдэвчилсэн сургалт явуулсан тоо, бүртгэл, баталгаажилт - Өдөрлөг, аянд оролцох, телевизийн нэвтрүүлэгт орох, сонин сэтгүүлд зөвлөмж бэлтгэх, - Сургалтын материал, гарын авлага, зөвлөмж, санамж, боловсруулж мэдээллийн самбарт тавьсан байдал, видео дэлгэц	5 оноо	Хийгээгүй 0 оноо Баримтгүй бол-3 оноо
4.5	Эмнэлгийн тусламж үйлчилгээний стандарт мөрдөлт, журмын зөрчил, үйлчлүүлэгчдийн аюулгүй байдлыг	- Үл тохирол, стандартын хүндрэл гаргасан эсэх /тарилгын, уян зүүний хүндрэл, нярайн эгэм хугарал, цус алдалт, Хязангийн урагдал 2,3,4/ Үйлчлүүлэгчийг зөв таних: - Овог нэр, төрсөн он сар өдөр, бүртгэлийн дугаар	5 оноо	Стандарт мөрдөлтийн хүндрэл гаргасан бол 0 оноо Тохиолдол бүрээс -1 оноо

	хангаж ажилласан байдал	- Эм өгөх / 5 зөв баримтлах/ - Цус, цусан бүтээгдэхүүн сэлбэх - Шинжилгээ авах - Ямар нэгэн ажилбарын өмнө Үр дүнтэй харилцааг бий болгох - Үйлчлүүлэгчийг хүлээлгэж өгөх үеийн мэдээлэл солилцоо Өндөр эрсдэлтэй эмийн аюулгүй байдлыг хангасан эсэх - Эмийн хадгалах хугацаа, жор, бэлтгэх арга, тарих, өгөх арга, хяналт зэрэг аюулгүй байдлыг хангасан эсэх - Өндөр эрсдэлт эмийн байрлал, шошго, хадгалалт Зөв талбай, Зөв ажилбар, Зөв үйлчлүүлэгчийн мэс засал - Мэс заслын өмнөх баталгаажуулалт / - Материал хэрэгслийн бүрэн бүтэн байдал - Материал тоолж шалгах, сорьцонд шошго наах Эх, нярай, үйлчлүүлэгчийн унах эрсдлийг үнэлж арга хэмжээ авсан байдал	Тухайн тохиолдлын давтамж бүрийн тоогоор оноо хасагдана
Нийт оноо 30			

Нийслэлийн Өргөө амаржих газрын даргын
2020 оны 04 дүгээр сарын 10 -ний өдрийн
1/30 тушаалын тавдугаар хавсралт

1119287569 9077006

Эрүүл мэндийн бусад ажилтнуудын ажлын үр дүн,
гүйцэтгэлийн үнэлгээний шалгуур үзүүлэлт

№	Шалгуур үзүүлэлт	Шалгуурын дагуу хийсэн ажил	Авах оноо	Үнэлгээ
А.НИЙТЛЭГ ШАЛГУУР				
3. Үйлчилгээ хүлээгдэл, чирэгдэл Харилцаа хандлага, ёс суртахууны хэм хэмжээ				
1.1	Хүлээгдэл, чирэгдэл үүсгэсэн байдал	Тасгуудад засвар үйлчилгээ үзүүлсэн	5 оноо	1 удаа- 1 оноо 2-3 удаа – 3 оноо 4 ба түүнээс дээш – 0 оноо
1.2	Харилцаа, хандлага, ёс суртахууны хэм, хэмжээ	Удирдах ажилтан, эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн ажилтан, үйлчлүүлэгчтэй харилцах хэм хэмжээг мөрдөн ажиллаагүй / Ёс зүйн доголдол гаргасан эсэх/	20 оноо	Ёс зүйн хэсгийн хороонд хандсан, хурлаар орсон бол 20 оноо Асуудал үүсгэсэн бол 15 оноо
1.3	Үйлчилгээний сэтгэл ханамж	Хамт олон, үйлчлүүлэгчээс санал хүсэлтийн хайрцаг, дэвтэр, талархалын модонд ирсэн сэтгэл ханамж	5 оноо	Тийм, үгүй
Нийт 30 оноо				
4. Ажлын ачаалал, цаг ашиглалт, хариуцлага Анхан шатны бичиг баримтын хөтлөлт				
2.1.	Ажлын цаг ашиглалт	Үйлчилгээний ажилтны яриа, сургалтын бүртгэл /эмнэлгийн магадлагаа, ээлжийн амралтын хугацаа тооцогдохгүй/	5 оноо	1 удаа- 2 оноо 2-3 удаа – 3 оноо 4 ба түүнээс дээш – 0 оноо
2.2	Анхан шатны бичиг баримтын хөтлөлт	Анхан шатны бичиг баримтын хөтлөлт /Засвар үйлчилгээ хийсэн бүртгэлийг үнэн зөв тэмдэглэх, засвар үйлчилгээ хийсэн он, сар өдөр, цаг хугацааг бичээгүй, дэс дараалалтай бус, хүснэгтэнд мэдээллийг буруу бичих, нөхөж бичих, засварлах, устгах, хуудас солих	5 оноо	1 удаа- 2 оноо 2-3 удаа – 3 оноо 4 ба түүнээс дээш – 0 оноо
2.3.	Өмч хөрөнгийн ашиглалт	Өмч, хөрөнгийн ашиглалт, хамгаалалт, аюулгүй ажиллагааны дүрэм, журам мөрдөн ажиллах	5 оноо	1 удаа- 2 оноо 2 ба түүнээс дээш – 0 оноо
2.4.	Ижил мэргэжилтний үнэлгээ	Алба, тасагтаа хийсэн ижил мэргэжилтний үнэлгээний хувь, үр дүн, цаашид дэвшүүлсэн асуудал, хэрэгжүүлсэн үйл ажиллагаа	5 оноо	Хийгээгүй бол-0 оноо Хийсэн баримтгүй бол -3 оноо

				Баримттай дүгнэлттэй бол-5 оноо
Нийт 20 оноо				
3.Эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд оруулсан хувь нэмэр				
3.1.	Үргүй зардал, шинэ санаа	Үргүй зардлыг багасах, шинэ бүтээл, оновчтой санааг нэвтрүүлсэн	5 оноо	Тийм, үгүй
3.2.	Аюулгүй ажиллагааны мөрдөлт, ажлын байрны бэлэн байдал	Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны бэлэн байдлыг хангах	10 оноо	Хангаагүй бол 0
3.3.	Олон нийтийн ажлын оролцоо	Удирдлага, хамт олноос зохион байгуулагдсан ажилд оролцсон байдал	5 оноо	Тийм, үгүй
Нийт			20 оноо	
Бүгд 70				
Б.ТУСГАЙ ШАЛГУУР				
4.Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар сайжруулах чиглэлд				
4.1.	Албан тушаалын тодорхойлолтод заагдсан ажлын гүйцэтгэл	Аюулгүй ажиллагааны мөрдөлт, ажлын байрны бэлэн байдлыг ханган ажилласан	5 оноо	Биелүүлсэн Биелүүлээгүй
4.2.	Халдвар хамгааллын дэглэмийг мөрдөж байгаа байдал	ХСХА-аас авсан мэдээлэл, стандартын дагуу хувцаслалт, Халдвар хамгаалалын дэглэм мөрдөлт, Халдваргүйжүүлэх бодисыг үйлдвэрлэгчийн зааврын дагуу найруулж хэрэглэх. /угаалгын нунтаг,хлорын шохой г.м/	7 оноо	1 удаа- 4 оноо 2-3 удаа – 3 оноо 4 ба түүнээс дээш –0 оноо
4.3.	Гомдол	ЗГ-ын 11-11, Хэрэглэгчийн үйлчилгээний төвийн 1800-1200, удирдах дээд байгууллага, үйлчлүүлэгчээс ирсэн аман, бичгэн гомдол	8 оноо	Гаргасан 0
4.4	Тайлан, үүрэг даалгавар	Удирдах ажилтнаас өгсөн үүрэг даалгаврын биелэлт	5 оноо	Хийгээгүй – 0 оноо Баримтгүй бол- 3 оноо
4.5	Стандарт мөрдөлт, хөдөлмөрийн дотоод журам мөрдөлт	Холбогдох стандарт, дүрэм, журмын мөрдөлт	5 оноо	Мөрдөөгүй 0
Нийт оноо 30				